БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Түргэн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/161/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит ХХК-ийн туслах аудитор: Б.Төртүвшин<br>Утас: 95669092, Цахим хаяг: baynjanjinxishig@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ............ **Error! Bookmark not defined.**
Дүгнэлтийн үндэслэл ............ 3
Асуудлыг онцолсон хэсэг ............ 3
Аудитын гол асуудал ............ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ............ 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ............ 12
4.1 Ерөнхий зүйл ............ 16
4.2 Материаллаг байдал ............ 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ............ 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ............ 17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ............ 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ............ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026-01-30 №УВА-2026/161/НА-СТА-ТШ3

танай____________-ны №____________-т

ТҮРГЭН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ГАНЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түргэн сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Түргэн сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулсан,тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050314

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **168,269,208.33** | **91,783,034.74** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 99,122,847.03 | 22,854,061.64 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 99,122,847.03 | 22,854,061.64 |
| **3121** | **Төгрөг** | 99,122,847.03 | 22,854,061.64 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 99,122,847.03 | 22,854,061.64 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 69,146,361.30 | 68,928,973.10 |
| **351** | **Түүхий эд материал** | 88,600.00 | 00.00 |
| 35130 | Эм боох материал | 88,600.00 | 00.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 69,057,761.30 | 68,928,973.10 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 629,155.00 | 828,655.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 65,406,925.00 | 64,927,377.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,360,000.00 | 1,660,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,661,681.30 | 1,512,941.10 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **427,081,875.27** | **414,533,445.67** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 427,081,875.27 | 414,533,445.67 |
| **392** | **Биет хөрөнгө** | 417,419,875.27 | 404,871,445.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 478,266,532.00 | 478,266,532.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -86,015,519.80 | -100,095,577.60 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 68,457,761.00 | 61,737,861.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -48,360,685.21 | -45,117,199.60 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 48,500,112.51 | 49,777,657.47 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -45,663,215.23 | -41,932,717.60 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,234,890.00 | 2,234,890.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 9,662,000.00 | 9,662,000.00 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -300,000.00 | -300,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,662,000.00 | 9,662,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **595,351,083.60** | **506,316,480.41** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **595,351,083.60** | **506,316,480.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 595,351,083.60 | 506,316,480.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 410,456,209.00 | 410,456,209.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 410,456,209.00 | 410,456,209.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 35,947,902.93 | -53,086,613.59 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 35,947,902.93 | 35,947,989.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -89,034,603.19 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 148,946,971.67 | 148,946,885.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **595,351,083.60** | **506,316,480.41** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **617,928,200.00** | **622,595,014.58** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **14,217,500.00** | **7,704,514.58** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 14,217,500.00 | 7,704,514.58 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 6,949,714.58 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 3,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 3,949,714.58 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **603,710,700.00** | **614,890,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 570,608,600.00 | 587,045,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 570,608,600.00 | 587,045,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 33,102,100.00 | 27,844,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 33,102,100.00 | 27,844,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **579,207,270.06** | **711,523,814.29** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **579,207,270.06** | **711,523,814.29** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 577,214,920.22 | 703,817,931.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 412,327,586.00 | 531,524,857.00 |
| 210101 | Үндсэн цалин | 255,369,443.00 | 296,215,657.00 |
| 210102 | Нэмэгдэл | 142,447,433.00 | 188,551,457.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 16,375,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,510,710.00 | 30,382,743.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,047,611.10 | 64,456,554.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,226,684.23 | 45,025,109.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,048,274.47 | 4,692,529.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,028,025.42 | 2,346,315.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,896,462.90 | 2,114,900.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,848,164.08 | 10,277,699.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,414,750.16 | 30,020,331.56 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,602,678.60 | 5,498,258.92 |
| 210302 | Түлш, халаалт | 25,362,071.56 | 23,742,072.64 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 450,000.00 | 780,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,655,975.00 | 10,335,016.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,710,000.00 | 3,077,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,046,970.00 | 3,465,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,659,721.00 | 1,555,968.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 30,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 920,300.00 | 1,571,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 10,318,984.00 | 634,548.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,998,432.36 | 36,812,190.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 122,000.00 | 213,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 33,876,432.36 | 36,510,590.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 88,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,186,000.00 | 4,236,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,186,000.00 | 4,236,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,824,000.00 | 1,360,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,824,000.00 | 1,360,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,058,000.00 | 1,529,906.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 337,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 288,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 770,000.00 | 1,192,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 106.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 25,702,565.60 | 23,542,276.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,829,608.00 | 1,871,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,809,300.00 | 1,372,250.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 22,063,657.60 | 20,299,026.12 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,992,349.84 | 7,705,883.02 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 7,680,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 7,680,900.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,992,349.84 | 24,983.02 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,992,349.84 | 24,983.02 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **38,720,929.94** | **-88,928,799.71** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 105,803.48 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 105,803.48 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -105,803.48 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **38,720,929.94** | **-89,034,603.19** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **603,710,700.00** | **617,890,500.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **3,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 3,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 3,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 3,000,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **603,710,700.00** | **614,890,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 570,608,600.00 | 587,045,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 570,608,600.00 | 587,045,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 33,102,100.00 | 27,844,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 33,102,100.00 | 27,844,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **546,889,282.10** | **687,022,685.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **546,889,282.10** | **687,022,685.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **544,896,932.26** | **679,316,802.37** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 412,327,586.00 | 531,524,857.00 |
| 210101 | Үндсэн цалин | 255,369,443.00 | 296,215,657.00 |
| 210102 | Нэмэгдэл | 142,447,433.00 | 188,551,457.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 16,375,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,510,710.00 | 30,382,743.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,047,611.10 | 64,456,554.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,226,684.23 | 45,025,109.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,048,274.47 | 4,692,529.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,028,025.42 | 2,346,315.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,896,462.90 | 2,114,900.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,848,164.08 | 10,277,699.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,609,750.16 | 26,469,616.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,602,678.60 | 5,498,258.92 |
| 210302 | Түлш, халаалт | 25,102,071.56 | 19,792,358.06 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 905,000.00 | 1,179,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,708,386.00 | 36,361,850.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,708,386.00 | 36,361,850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,500,000.00 | 1,350,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 1,350,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,420,500.00 | 2,291,246.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,420,500.00 | 2,291,246.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,283,099.00 | 16,862,678.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,497,499.00 | 12,940,828.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,785,600.00 | 3,921,850.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,992,349.84** | **7,705,883.02** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 7,680,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 7,680,900.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,992,349.84 | 24,983.02 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,992,349.84 | 24,983.02 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **56,821,417.90** | **-69,132,185.39** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,500,000.00** | **7,136,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,500,000.00** | **7,136,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,500,000.00 | 7,136,600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,500,000.00 | 7,136,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1,500,000.00** | **-7,136,600.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 55,321,417.90 | -76,268,785.39 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 43,801,429.13 | 99,122,847.03 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 99,122,847.03 | 22,854,061.64 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 400,794,209.00 | 1,013,992.66 | -18,640,375.58 | 00.00 | 383,167,826.08 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **400,794,209.00** | **1,013,992.66** | **-18,640,375.58** | **00.00** | 383,167,826.08 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 8,398,223.51 | 00.00 | 8,398,223.51 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **410,456,209.00** | **148,946,971.67** | **35,947,902.93** | **00.00** | 595,351,083.60 |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **410,456,209.00** | **148,946,971.67** | **35,947,902.93** | **00.00** | 595,351,083.60 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 86.67 | 00.00 | 86.67 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **410,456,209.00** | **148,946,971.67** | **35,947,989.60** | **00.00** | 595,351,170.27 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -86.67 | 00.00 | 00.00 | -86.67 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -89,034,603.19 | 00.00 | -89,034,603.19 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **410,456,209.00** | **148,946,885.00** | **-53,086,613.59** | **00.00** | 506,316,480.41 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 679,369,000.00 | 666,314,685.39 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 679,369,000.00 | 666,314,685.39 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 671,688,100.00 | 658,633,785.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 534,904,500.00 | 531,524,857.00 |
| 210101 | Үндсэн цалин | 325,230,700.00 | 296,215,657.00 |
| 210102 | Нэмэгдэл | 191,647,200.00 | 188,551,457.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 16,375,000.00 |
| 210104 | Урамшуулал | 18,026,600.00 | 30,382,743.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,480,200.00 | 64,456,554.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,084,100.00 | 45,025,109.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,349,000.00 | 4,692,529.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,674,500.00 | 2,346,315.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,674,500.00 | 2,114,900.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,698,100.00 | 10,277,699.04 |
| **2105** | **Нормативт зардал** | 40,466,800.00 | 36,361,850.00 |
| 210502 | Хоол, хүнс | 40,466,800.00 | 36,361,850.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,311,100.00 | 2,291,246.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,311,100.00 | 2,291,246.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27525500.00 | 23999278.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,571,000.00 | 20,077,428.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,954,500.00 | 3,921,850.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,680,900.00 | 7,680,900.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,680,900.00 | 7,680,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,680,900.00 | 7,680,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 679,369,000.00 | 590,045,900.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 585,528,300.00 | 587,045,900.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 585,528,300.00 | 587,045,900.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 93,840,700.00 | 3,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,000,000.00 | 3,000,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 87,840,700.00 | 00.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 99,122,847.03 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 22,854,061.64 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 00.00 | 00.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 00.00 | 00.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 18.50 | 18.50 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 10.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07.50 | 07.50 |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **27,844,600.00** | **27,819,616.98** | **24,983.02** | **99.9%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **27,844,600.00** | **27,819,616.98** | **24,983.02** | **99.9%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **27,844600.00** | **27,819,616.98** | **24,983.02** | **99.9%** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **26,494,600.00** | **26,469,616.98** | **24,983.02** | **99.9%** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 5,251,000.00 | 5,498,258.92 | -247,258.92 | 104.7% |
| 210302 | Түлш, халаалт | 18,383,800.00 | 19,792,358.06 | -1,408,558.06 | 107.7% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,859,800.00 | 1,179,000.00 | 1,680,800.00 | 41.2% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,350,000.00** | **1,350,000.00** | | **10.0%** |
| 210604 | Урсгал засвар | 1,350,000.00 | 1,350,000.00 | | 100.0% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **27,844,600.00** | **27,819,616.98** | **24,983.02** | **99.9%** |
| **1310** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **27,844,600.00** | **27,819,616.98** | 24,983.02 | **99.9%** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 27,844,600.00 | 27,819,616.98 | 24,983.02 | 99.9% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **18.50** | **18.50** | | **100%** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | **10.00** | **10.00** | | **100%** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.50 | 7.50 | | 100% |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

"Хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан, тоглонгоо суралцаж, танин мэдэхүй, нийгэмшлийн суурь чадамжийг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлж, хүүхэд бүрийг хөгжүүлнэ" гэсэн зорилго тавин үйл ажиллагааг явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Түргэн сумын Цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр,12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр
- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус шинэчлэн тогтоосон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түргэн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түргэн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89,034.6 мянган төгрөгөөр буюу 15 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 99,122.8 | 22,854.1 | -76,268.7 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 69,146.4 | 68,928.9 | 217.5 |
| Үндсэн хөрөнгө | 427,081.9 | 414,533.4 | -12,548.5 |
| **Нийт хөрөнгө** | **595,351.1** | **506,316.5** | **-89,034.6** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 595,351.1 | 506,316.5 | -89,034.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **595,351.1** | **506,316.5** | **-89,034.6** |

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 76,268.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 68,928.9 мянган төгрөг болж 217.5 мянган төгрөгөөр буурсан нь хүнсний материалын эхний үлдэгдэлээс зарлага гарсан байна. Бараа материал дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 414,533.4 мянган төгрөг болж, 12,548.5 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал өссөнтэй холбоотой .

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 506,316.5 мянган төгрөг болж 89,034.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 520,642.4 мянга,орон нутгийн төсвөөс 27,844.6 мянган төгрөг нийт 548,487.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 64,885.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 587,045.9 мянга, урьд оны үлдэгдлээс санхүүжих 87,840.7 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 3,000.0 мянга, нийт 677,886.6 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 666.314.7 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд оны эхний үлдэгдлээс 11,282.1 мянган төгрөгийн санхүүжүүлэлтийг дутуу олгосон байна

Орон нутгийн төсвөөс гүйцэтгэлээр 27,819.6 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж түлш халаалтын зардалд 19,792.3 мянга, гэрэл цахилгааны зардалд 5,498.2 мянга, цэвэр усны зардалд 1,179.0 мянга, урсгал засварын зардалд 1,350.0 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 24.9 мянган төгрөг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 694,134.3 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 3,379.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2,023.6 мянга, нормативт зардлыг 4,104.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,526.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 38,870.8 | 34,765.8 | 4,104.9 | 89.4% |
| 2 | Хүүхэл хамгаалал | 955.6 | 955.6 | 0.00 | 100% |
| 3 | Эрүүл мэндийг дэмжих | 865.4 | 855.0 | 10.40 | 98.7% |
| 4 | Нүүдлийн бүлэгт хамруулах | 25,578.9 | 24,161.8 | 1,417.0 | 94.4% |
| 5 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 1,437.6 | 1,437.6 | 0.00 | 100% |
| 6 | Боловсролын байгууллагын багш ажитны мэргэжил дээшүүлэх | 822.1 | 820.0 | 2.1 | 99.7% |
| 7 | Боловсролын стандарт ,сургалтн орчин | 581,095.4 | 579,182.5 | 1,912.8 | 99.6% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 23,742.3 | 21,132.2 | 2,606.9 | 89% |
| 9 | Гүнзгийрүүлсэн боон төрөлжсөн | 6,000.0 | 3,000.0 | 3,000.0 | 50% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн**

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Программ хангамж | - | - | Байгууллагын үйл ажиллагаанд 300.0 мянган төгрөгийн программ ашиглаж байна. |
| 2 | Унаа,хоолны зардал | - | 16,375.0 | 2025 онд унаа, хоолны зардалын төсөв гэж төсөвлөөгүй бөгөөд цалингийн зардалаас 16,375.0 мянган төгрөг олгосон. |
| 3 | Сургалт ,семинар | - | - | Тухайн байгууллагад төсөвлөгдсөн зардал байхгүй . |
| 4 | Гадаад томилолт,арга хэмжээ | - | - | Гадаад томилолт,арга хэмжээ зардал гараагүй байна. |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал | - | - | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна. |
| 6 | Хэвлэл мэдээлэл | - | - | Тайлант жилд хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ хийгээгүй. |
| 7 | Орон тоо | 534,904.5 | 531,524.8 | Түргэн сумын Цэцэрлэг нь 2025 онд 18.5 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж 534,904.5 мянган төгрөгийн цалингийн зардал батлагдсанаас тайлант онд 531,524.8 мянган төгрөгийг ажилчдын цалин хөлс,урамшуулалд зарцуулсан байна. |

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Түргэн сумын Цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

**3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Түргэн сумын Цэцэрлэгийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

**3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Түргэн сумын Цэцэрлэг нь хүүхдийн хоолны шууд худалдан авалтыг 6 багц бүтээгдэхүүнд 43,692.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дугаар сарын 10-ны өдөр tender.gov.mn цахим хуудсанд байршуулан худалдан авалтыг зохион байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Түргэн сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн туслах аудитор Б.Төртүвшин гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Түргэн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 546,105.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 54,610.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 711,523.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 7,115.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,692.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Түргэн сумын Цэцэрлэгийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2 хугацаандаа оруулсан 169 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Түргэн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Түргэн сумын Цэцэрлэгийн хувьд дараагийн аудитаар анхаарах чухал асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 105.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж баталгаажуулав.

Залруулсан алдаа

- Үр дүнгийн тайланд 105.8 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахдаа 105.8 мянган төгрөгийн гарз хүлээн

зөвшөөрөөч үр дүнгийн зардлаар тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн 105.8 мянган төгрөгийг залруулллаа.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үлдэх өртөгтэй хөрөнгө актахдаа гарзыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй | 1 | 105.8 | | | | | 1 | 105.8 | | | | |
| ДҮН | 1 | 105.8 | | | | | 1 | 105.8 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт дүн | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн ТУСЛАХ АУДИТОР /Б.ТӨРТҮВШИН/

2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр